

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГТ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАДААДЫН ТӨСӨЛ
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГТ ХЭРЭГГИЖ БУЙ ГАДААДЫН ТӨСӨЛ
ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ТОВЧОО / 2017 ОН /

№	Агуулга	Хэрэгжүүлэх зорилтын тоо	Хэрэгжилтийн явц				Үнэлэх боломжгүй	Хувь %
			100	70	30	0		
1	Залуучуудын хөгжлийн төв	3	2	1				90
2	Хайлааст орон нутгийн хөгжлийн хөтөлбөр	4	3	1				92,5
3	Монгол улс дахь хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь	1	1					100
4	Өрхийн тогтвортой тариалан	1	1					100
Дүн		6						95,6

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГТ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАДААДЫН ТӨСӨЛ
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ
Залуучуудын хөгжлийн төв**

№	Хөтөлбөр/төслийн агуулга		Гүйцэтгэл		
1	Хөтөлбөрийн нэр: Залуучуудын хөгжил		Хөтөлбөрийн зорилго: 15-34 насны ялангуяа нийгмийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байгаа өсвөр үе, залуучууд мэдлэг чадвартай, өөртөө итгэх итгэл, амьдрах ухаан, ур чадвар бэхжиж, эерэг, хариуцлагатай, бие даах зан үйлийг төлөвшүүлэх.		
2	Санхүүжилтийн эх үүсвэр		НҮБ		
3	Хэрэгжүүлэгч байгууллага / хэрэгжих нийт хугацаа/		Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХНХЯ, ГБХЗХГ Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Хороодын Иргэний танхим, Засаг даргын ажлын алба, Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн хэлтэс , Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Иргэний оролцооны хэлтэс		
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		Зорилт 1: Амьдрах ухаан сургалт явуулах Зорилт 2: Дэмжих бүлгүүд ажиллуулах. Зөвөлгөө өгөх. Зорилт 3: Залуучуудын оролцооны үйл ажиллагаа явуулах, өсвөр үе залуучуудын хөгжлийг хангахад чиглэсэн бусад үйл ажиллагаа явуулах.		
5	Зардал	Төсөв /Нийт шаардагдах зардал/			
		Үүнд:	Төсөв/он/	Гүйцэтгэл	Хувь
		Багц 1	2,250,000	2,249,758	
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт Зорилт 1: Амьдрах ухаан сургалт явуулах		Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ. Чингэлтэй дүүргийн 15, 16, 18-р хорооны 48 залуучуудад “Өөртөө итгэх илтгэл” сэдвээр 2 цагийн сургалтыг зохион явуулсан. Энэхүү сэдвээр Өөртөө итгэх итгэл гэсэн ойлголтыг тайлбарлах, нөлөөлдөг хүчин зүйлсийг нэрлэх, өөрийнхөө талаар төсөөлөл, мэдрэмжийг сайжруулах зэрэг чадварт суралцсан. 2017 оны 05 дугаар сарын 6, 7-нд Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны Иргэний танхимтай хамтран тус дүүргийн 3, 10, 11, 18-р хорооны Хүүхэд харах үйлчилгээний залуу багш нарт зориулан Амьдрах ухаан, амьжиргааны ухааны ялгаа, Амьдрах ухааны хичээлээр юунд суралцах вэ? Өөртөө итгэх итгэлийг тодорхойлох, түүнийг үнэлэх дүгнэх Би хэн бэ? Өвөрмөц байх болон өөртөө итгэх итгэл? Хяналт эрх мэдэл ба өөртөө итгэх итгэл сэдвээр 4 цагийн хичээлийг нийт 21 иргэнд / эр - 3, эм – 18/ амжилттай зохион байгуулсан. 2017 оны 06 дугаар сарын 07-нд Чингэлтэй дүүргийн 37 дугаар сургуулийн залуу багш нарт “Харилцаа” Сэдвийн хүрээнд Харилцаа ба түүний хэлбэрүүд? Харилцааны хэлбэр, түүний үр дагаварыг тодорхойлох? Харилцаанд нөлөөлөх хүчин зүйл? дэд		

	<p>сэдвийн хүрээнд хичээлийг явуулсан. Сургалтад тус сургуулийн 25-35 насны 18 багш хамрагдсан бөгөөд дээрхи сэдвийн талаар олж авсан мэдлэг мэдээллээ амьдралдаа хэрэгжүүлэх ахлах ангийн сурагчдад ойлгуулах чадварт суралцсан.</p> <p>Ахлах ангийн сурагчдад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд түүний бүрэлдэхүүн хэсэг болох гэр бүл төлөвлөлт, өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэнд гэх мэт асуудлаар зөв мэдээлэл мэдлэг олгох, үе тэнгийн сургагч багшийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Мэдлэгийн өртөө” өртөөчилсэн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад ахлах ангийн 145 хүүхэд хамрагдсан.</p> <p>ЕБС-ын 37,17,61-р сургуулиудад Өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлж дүгнэх сэдвийн хүрээн дор “Би хэн бэ? “Өвөрмөц байх Хяналт эрх мэдэл ба өөртөө итгэх итгэл” “Бэлгийн амьдралал гэж юуг хэлэх вэ?” сэдвээр хичээл заасан. Энэхүү хичээлээр хүүхэд зөв үерхэл нөхөрлөл, зөв дадал зуршилд суралцсанаар өөрт хэр их үр нөлөөтэй талаар Өөртөө итгэх итгэл гэдэг хичээлээр өөрийнхөө авьяас чадварыг нээх, өөрийгөө хөгжүүлэх, чадварт суралцсан. 9, 15, 17, 18 дугаар хорооны 15-33 насны 31 иргэдэд Амьдрах ухаан, Амьжиргааны ухааны ялгаа, амьдрах ухааны хичээлээр юунд суралцах вэ? Амьдрах ухаанд суралцсанаараа давуу тал нь юунд оршиж байна вэ? сэдвийн хүрээнд “Өөртөө итгэх итгэлтэй байх” “Хорт зуршил”2 цагийн хичээлийг явуулсан. Энэхүү хичээлээр эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хэрхэн зөв харилцах вэ? Зөв үлгэр дууриалал үзүүлэх зэрэг чадварт суралцсан. Амьдрах ухааны сургалтад нийт 104 сурагч /эр-43 эм-61/ сургалтад хамрагдсан нийт хүмүүсээс сэтгэл ханамжийн судалгаа авсанаас нийт 104 хүн судалгаанд оролцсоноос сэтгэл ханамж өндөр 87 /эр-32 эм- 55/ байна. 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр 72, 34,17-р сургуулийн Ахлах ангийн сурагчдад бэлгийн амьдрал гэж юу вэ? болон нөхөн үржихүйн эрүүл мэнд түүний бүрэлдэхүүн хэсэг болох гэр бүл , өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, зөв мэдээлэл мэдлэг олгох , үе тэнгийн сургагч багшийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “ бэлгийн амьдрал гэж юу вэ? Хүсээгүй жирэмслэлт, хорт зуршил ба архи тамхи 2 сэдвээр 5 өртөө ажиллуулан сурагчдад нөхөн үржихүйн эрүүл мэндийн сэтгэлзүйн зөвлөгөө өгсөн. Мөн сурагчдын сонирхсон асуулт бүр дээр хариулт өгч Чингэлтэй дүүргийн Өсвөр үе клиникийн төвийн үйл ажиллагаа болон ямар үйлчилгээ үзүүлдэг , хаяг байршлын талаар 142 хүүхэд, үүнээс: /эр -58 эм – 84/ мэдээлэлтэй болсон.</p> <p>Нийслэлийн залуучуудын хөгжлийн газраас Нийслэлийн иргэний дагаж мөрдөх зөв 10 дадал аяныг “Эерэг амьдарцгаая залуучуудаа” уриан дор нийт 265 залуучууд идэвхтэй оролцож, санал бодлоо илэрхийллээ.</p> <p>2017 оны 09 дүгээр 28-нд 17-р сургууль 49-р дунд сургууль 10 дугаар сарын 13-нд 72-р дунд сургууль “Согтууруулах ундаа, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх аяны” хүрээн дэхь сургалтыг Сэтгэцийн эрүүл мэндийн төв, Нийслэлийн залуучуудын хөгжлийн газар, Залуучуудын төв хамтран 380 / Эр-230 эм-150/ ахлах ангийн сурагчдад хүргэсэн.</p> <p>Монголын өсвөр залуу үеийнхний хүмүүжил, төлөвшилд нөлөөлөх, тэдний ирээдүйн ажил амьдрал, зорилгоо тодорхойлоход нь туслах зорилгоор “Амьдрах ухааны</p>
--	---

		<p>чадвар” олгох сургалт явуулдаг. Хөтөлбөрийн дагуу ерөнхий боловсролын 61, 117, 72, 49 дүгээр сургуулиудад, 10-12-р ангийн нийт 113 / эрэгтэй 48, эмэгтэй 65 /сурагчдад хичээл орсон. Мөн 72-р сургуулийн эцэг эхийн зөвлөлийн санаачлагаар ”Өөртөө итгэх итгэлтэй байх”, “Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах” сэдвээр тус тус орсон. Сургалтанд хамрагдсан сурагчид өөртөө итгэх итгэлтэй байхын ач тус, сэтгэлийн хөдөлгөөнөө хянах талаар мэдлэгтэй болж амьдралдаа хэрэгжүүлэхээр боллоо.</p>
	<p>Зорилт 2: Дэмжих бүлгүүд ажиллуулах. Зөвөлгөө өгөх.</p>	<p>Залуучуудын хөгжлийн төвийн дэргэд “Өсвөр насны охид”-ын “Бүтээлч хүүхдүүд”, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй залуу ээжүүдийн “Бид цоглог ээжүүд” гэсэн 2 дэмжих бүлэг тус бүр 6 гишүүнтэй нийт 12 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Дэмжих бүлгүүдийг төвийн нийгмийн ажилтан үйл ажиллагааг нь чиглүүлэн ажилласан. Үүний үр дүнд бүлгийн гишүүд бие даан үйл ажиллагаа явуулах чадварт суралцаж, эргэх холбоотой тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна. Дэмжих бүлгүүдийн 12 гишүүдийн идэвх оролцоо, шинэ санал санаачлагуудыг дэмжих зорилгоор “Аз жаргалтай гэр бүл”, ” Хөгжмийн сургалт” “Аавуудын баярын өдөр”-ийн зэрэг арга хэмжээнүүдэд оролцуулж, мэдээлэл өгсөн.</p> <p>2017 оны 10 дугаар сарын 20-ны байдлаар нийт 164 хүн сэтгэлзүйн сургалт зөвөлгөөнд /110 -эр 54-эмэгтэй/ хамрагдсан. Онцгой байдлын хэлтсийн 110 албан хаагчдад Гэр бүл төлөвлөлт, Гэр бүл төлөвлөлтийн сэтгэлзүйн зарим асуудал 5-р сургуулийн ахлах ангийн төлөөлөл болсон 40 охидод өсвөр насны сэтгэлзүйн зарим асуудал сэдвээр сургалт орсон. Сэтгэлзүйн бүлгийн зөвөлгөө 150 гэр бүлийн маргаан-5 бие махбодын хүчирхийлэл -2 бэлгийн хүчирхийлэл -1 хүүхдийг үл хайхрах байдлаар 5 насанд хүрээгүй хүүхдийн жирэмслэлтийн байдал 1 хүнд сэтгэлзүйн зөвөлгөө өгсөн.</p> <p>Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан залуучууд хөгжлийн төвийн дэргэдэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй залуу ээжүүдийн дэмжих бүлгийн гишүүд”-ийн хүүхдүүдийн баярын арга хэмжээг “ДЗМОУБ-ын Хайлааст ОНХХ”-тэй хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 31 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн төлөөлөл оролцож, хүүхдүүдэд баярын мэнд дэвшүүлж гарын бэлэг гардуулан өгсөн. Шүр, цаасан урлалын сургалтыг “Өсвөр насны охид”-ын “Бүтээлч хүүхдүүд”, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй залуу ээжүүдийн “Бид цоглог ээжүүд” дэмжих бүлгийн гишүүдэд 2017 оны 04 дүгээр сараас – 2017 оны 07 дугаар сарыг хүртэл зохион байгуулсан. Олон улсын хүүхдийн баярын арга хэмжээний үеэр 12 гишүүд хийсэн бүтээлүүдээрээ үзэсгэлэн гаргаж, үйл ажиллагаанд оролцсон албаны хүмүүс болон иргэдэд үзүүлж сонирхуулсан.</p>
	<p>Зорилт 3: Залуучуудын оролцооны үйл ажиллагаа явуулах, өсвөр үе залуучуудын хөгжлийг хангахад чиглэсэн бусад үйл ажиллагаа явуулах.</p>	<p>“Залуу эмэгтэйчүүдийн дуу хоолой” форум салбар хэлэлцүүлгийг салбар бүрийн төлөөллүүдээс бүрдсэн 40 залуу эмэгтэйчүүдийг хамруулан амжилттай зохион байгуулсан.</p> <p>“1000 идэвхтэй иргэн” залуучуудын хөгжлийн төслийн ээлжит сургалтыг “Миний бизнесийн амжилт” сэдвээр “Өгөөж” чихэр боов ХХК-ны захиралыг урьж бизнесийн санаагаа хэрхэн ажил хэрэг болгож амжилтанд хүрсэн талаар лекц ярилцлагыг зохион байгуулсан. Тус сургалтанд 15,16,18 дугаар хорооны 48 залуучууд /эр – 17, эм - 31/ хамрагдсан.</p>

		<p>Залуучуудын нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжилд тэдний санал санаачлагыг тусгах, тулгамдаж буй асуудлыг гаргаж шийдвэрлэх арга замыг олох, залуучуудын клубыг шинэчлэн байгуулж, идэвхижүүлэх зорилгоор 100 залуучуудын дунд “Залуучуудын оролцоо ба нөлөөлөл” зөвлөгөөнийг зохион байгуулсан. Зөвлөгөөний үеэр “Залуучуудын өнөөгийн байдал ба оролцоо” сэдвээр Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимын лекторыг урьж оролцогчдод харилцан ярилцах байдлаар лекц уншуулан, лекцэн дээрээ тулгуурлан, оролцогчдыг 5 бүлэгт хуваан хэлэлцүүлгийг өрнүүлсэн.</p> <p>"Аз жаргалтай гэр бүл өдөрлөг"-ийг дүүргийн 11, 12, 18, 19 хороодын ажлын алба, Чингэлтэй дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Залуучуудын хөгжлийн төв хамтран хороодын зорилтот залуу гэр бүлүүдийн дунд, гэр бүлд тулгамдаж байгаа асуудлын мөн чанар шалтгааныг тодорхойлон, асуудлаа шийдвэрлэх арга замуудыг бий болгох зорилгоор " Гэр бүлийн үнэ цэнэ" сургалтыг хороо тус бүр дээр 15 гэр бүл буюу 120 залуучуудын дунд зохион байгуулсан.</p> <p>Залуучуудын хөгжлийн төв нь амьд хөгжмийн хамтлаг гаргах зорилготой хөгжмийн сургалтыг явуулж 8 эрэгтэй 6 эмэгтэй 14 ахлах ангийн хүүхэд хичээллэж байна. Мөн интернет өрөөнд өдөрт тогтмол 6-оюутан 7- ахлах ангийн сурагч, Номын сангаар 11-ахлах ангийн сурагч 6- оюутан даваа мягмар пүрэв гаригуудад батлагдсан тогтмол хувиарын дагуу 9, 13, 15,16, 17, 18, 19 хорооны нийт 220 эр-163 эм-57 залуучууд спорт зааланд тоглож чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж байна.</p> <p>Анхан, Дунд шатны Компьютерийн сургалт хичээллэж эхэлсэн бөгөөд нийт 30 /эр-11 эм-19/ хүн бүртгүүлсэн.</p>				
7	Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/	<p>Залуучуудын хөгжлийн төв албан ёсны байргүй ч, өөрсдийн нөөц боломжинд тулгуурлан хороодын Иргэний танхим, ЕБС-дын урлаг заалуудыг түшиглэн дээрх үйл ажиллагаануудыг зохион байгуулж байна. Үүний үр дүнд дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх хэлтэс, албадуудтай уялдаа холбоо сайтай ажиллаж байна.</p> <p>Саад, бэрхшээл:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Төв өөрийн байргүй. /өдөр тутмын үйл ажиллагаа байхгүй/ ❖ ❖ Тухайн улирлын үйл ажиллагааны санхүүжилт цаг тухай бүрдээ орж ирдэггүйгээс болоод төлөвлөгөөт ажлууд хойшлогдож байна. <p>Ололт амжилт:</p> <p>Залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах болсноор залуучуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулж, хамрах хүрээг нэмэгдүүлж чадсан.</p>				
8	Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ					
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		90	3	100	100	70

	үнэлгээ, дүгнэлт /өөрийн үнэлгээ/					
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ /ЗГХЭГ-ын үнэлгээ/	Нэгдсэн үнэлгээ				

Хайлааст орон нутгийн хөгжлийн хөтөлбөр.

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл		
1	Хөтөлбөрийн нэр: Хайлааст орон нутгийн хөгжлийн хөтөлбөр 2.	Хөтөлбөрийн зорилго: Хүүхдийн хөгжил хамгаалал нөлөөллийн ажлыг зохион байгуулах. Тус дүүргийн 7-19 дүгээр хорооны хүүхдүүдэд чиглэсэн Хүүхэд хамгаалал, нөлөөлөл, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, чадавхжуулах.		
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Дэлхийн зөн олон улсын байгууллага.		
3	Хэрэгжих нийт хугацаа: 2017	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Дэлхийн зөн олон улсын байгууллагын Чингэлтэй Хайлааст орон нутгийн хөгжлийн хөтөлбөр. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Хүүхэд гэр бүл хөгжлийн төв.		
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1: Хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдэх гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, архины хор уршгийг олон нийтэд таниулах, архинаас гаргах, архины хамааралтай бусад иргэдэд нөлөөлөх ажлыг олон нийтэд таниулах. Зорилт 2: Хүүхдэд тулгамдаж буй асуудал, хүүхдийн санал хүсэлтийг төрийн байгууллагын бодлого шийдвэрт тусган хэрэгжүүлэх Зорилт 3: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хөгжүүлэх, тэдний эцэг, эхчүүдийг бүлэг зохион байгуулалтад оруулж хөдөлмөр эрхлүүлэх, эцэг эхийн оролцоо хандлагыг өөрчлөх, идэвхжүүлэх Зорилт 4: Залуу, дунд, ахмад үеийн гэр бүлийн уулзалт, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах		
5	Зардал	Төсөв /Нийт шаардагдах зардал/		
		Үүнд:		
		Төсөв/он/ 2017	Гүйцэтгэл	Хувь
	Багц 1	-	10.648.125	
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт	Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ.		
	Зорилт 1: Хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдэх гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй	Дүүргийн гэр бүл залуучуудын хөгжлийн хэлтэс 2017 оны 04 дүгээр сарын 10-наас 18-ны өдрүүдэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооцгооё” аяны хүрээнд		

<p>байдлыг хангах, архины хор уршгийг олон нийтэд таниулах, архинаас гаргах, архины хамааралтай бусад иргэдэд нөлөөлөх ажлыг олон нийтэд таниулах</p>	<p>дүүргийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн 1, 2-р хэлтэс Ерөнхий Боловсролын Сургуулийн нийгмийн ажилтнуудтай хамтран Чингэлтэй дүүргийн харьяа ЕБС-н ахлах ангийн 1236 хүүхдэд</p> <ol style="list-style-type: none"> 1. Цахим гадуурхал 2. Үе тэнгийн дарамт хүчирхийлэл 3. Хүүхдийн хөгжил, оролцоо 4. Хууль эрх зүй /Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын талаар мэдээллэл өгч ажилласан. <p>Монгол өрх ТББ-тай хамтран “Хүчирхийллийг таслан зогсооё” кейс хэлэлцүүлгийг 1-19 дүгээр хороодын Засаг дарга нар, хэсгийн байцаагчид, нийгмийн ажилтнууд, ГБХЗХХ-ийн ажилтнуудад 3 дугаар хорооны Иргэний танхимд зохион байгуулсан.</p> <p>“Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг хамтдаа” аяныг 2017 оны 4 дүгээр сарын 03-ний өдрөөс 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал дүүргийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн 1,2 дугаар хэлтэс, Боловсролын хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Чингэлтэй орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран зохион байгууллаа. Чингэлтэй дүүргийн төв Тусгаар тогтнолын талбайд 04 дүгээр сарын 30-ний өдөр “Хүүхдийн эрхийг дээдэлж, гэр бүлийн хүчирхийллийг зогсооцгооё” уриан дор ерөнхий боловсролын 12 сургуулийн 2000 гаруй сурагчид, Нутгийн захиргааны байгууллагын удирдлагууд, Төрийн бус олон нийтийн байгууллагын төлөөлөл оролцон хүчирхийллийн эсрэг хамтран тэмдэглэлээ.</p> <p>“Гэрээр айлчлагч аргачлал” төсөлд дүүргийн 13, 14, 18 дугаар хорооны 60 өрх хамрагдаж байгаа билээ. Тус хороодын нийгмийн ажилтнууд, төслийн гэрээр айлчлагч нартай хамтран “Гэр бүлийн баяр хөөр” 3 өдрийн сургалтыг 60 өрхийн 110 гаруй гишүүдэд явуулсан. Мөн тус төслийн хүрээнд сонгогдсон өрхийн гишүүдийн чадавхжуулах олон төрлийн сургалтанд хамруулах, хүүхдүүдэд хувцасны дэмжлэг олгох, өрхөд хүнсний болон түлээ нүүрсний дэмжлэг олгож ажилласан.</p> <p>Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хороодын хамтарсан багийг идэвхжүүлэх, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх, ажил, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, үр дүнг үнэлж, дүгнэх зорилготой “Хамтарсан багийн хамтын ажиллагаа” 3 сарын уралдаант аяныг зарлан, дүгнэж, 1 дүгээр байранд 7 дугаар хорооны хамтарсан баг, 2 дугаар байранд 9 дүгээр хорооны хамтарсан баг, 3 дугаар байранд 14 дүгээр хорооны хамтарсан баг тус тус орж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнуулсан.</p> <p>“Гэр бүлийн-баяр хөөр” ТББ-тай хамтран Иргэд олон нийтэд аливаа төрлийн донтолт, архины хор уршгийг сурталчлан таниулах зорилготой “ЭРҮҮЛ ХҮН-</p>
---	---

		<p>ЭРҮҮЛ ГЭР БҮЛ-ЭРҮҮЛ НИЙГЭМ” сэдэвт өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр “Эрүүл ба эрүүл бус гэр бүл, Архинд донтох өвчин, Залруулга” сэдвүүдийн хүрээнд сургалт явуулж, сургалтад 1-19 хороодын нийт 300 иргэн хамрагдав.</p>
	<p>Зорилт 2: Хүүхдэд тулгамдаж буй асуудал, хүүхдийн санал хүсэлтийг төрийн байгууллагын бодлого шийдвэрт тусган хэрэгжүүлэх</p>	<p>Нийслэлийн Хүүхэд, Гэр Бүлийн хөгжлийн газар, “Боловсрол ирээдүйн хөгжлийн гарц” ТББ-аас хамтран “Сайн засаглалд-Хүүхдийн оролцоо” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулж нийт 64 хүн оролцлоо. Уулзалтаар Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагууд хүүхэдтэй хамаатай аливаа асуудалд хүүхдийг оролцуулж дуу хоолой, санаа бодлыг сонсож тэдний хэрэгцээнд нийцсэн шийдвэр гаргахад хүүхдүүдтэй хамтран ажиллах талаар санал бодлоо солилцож, 2018-2021 он хүртэлх шинэ стратеги, шинэ стратегийн хүүхэд хамгааллын хөтөлбөрийн хэрэгжүүлэх гол аргачлал болох өсвөр насны хүүхдийн оролцоо, амьдрах ухааны чадварыг сайжруулах “Оролцоод хөгжье” аргачлалыг танилцуулж, Нийслэлийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн газраас нийслэлийн “Хүүхдийн насны үечлэлээр хөгжүүлэх” хөтөлбөрийн талаар мэдээлэл, танилцуулга хийсэн.</p>
	<p>Зорилт 3: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хөгжүүлэх, тэдний эцэг, эхчүүдийг бүлэг зохион байгуулалтад оруулж хөдөлмөр эрхлүүлэх, эцэг эхийн оролцоо хандлагыг өөрчлөх, идэвхжүүлэх</p>	<p>Дүүргийн ГБХЗХХэлтэс, 18 дугаар хорооны ИНХ-тай хамтран хөгжлийн бэрхшээлтэй 30 хүүхдийг “Эгшиглэнт чимээ” хамтлагийн тоглолтыг үзүүлж, ОУ-ын хүүхдийн “Найрамдал” зусланд 15 хүүхдийг өдрийн амралтад явуулж, “Хүүхэд хүмүүжлийн эерэг аргууд” болон “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээ” сургалтад 17,18 дугаар хорооны 25 эцэг, эхийг хамруулсан.</p> <p>Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгтэй хамтран нийслэлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх зорилготой “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” төслийн хүрээнд 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр 1-19 дүгээр хороодын нийгмийн ажилтнууд, Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүд, ӨЭМТөвийн нийгмийн ажилтанууд зэрэг нийт 40 хүнд “Тэгш хамруулах боловсрол ба үнэт зүйлд суурилсан орон нутгийн хөгжил” сэдэвт сургалт зохион байгуулагдсан.</p> <p>ИРИМ судалгааны хүрээлэнтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд тэгш хамруулан сургах “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” төслийг 13-19 дүгээр хороодод хэрэгжүүлж, төсөл хэрэгжиж байгаа хороод, сургуулийн нийгмийн ажилтан, захирал, холбогдох хүмүүсийг төслийн танилцуулга, судалгааны аргачлалын талаар үе шаттай сургалтад хамруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх үнэлгээний аргачлалын туршилтыг дүүргийн 17, 72, 37 дугаар Ерөнхий боловсролын сургуулиудын 5784 хүүхэд амжилттай явуулсан.</p>

	Зорилт 4: Залуу, дунд, ахмад үеийн гэр бүлийн уулзалт, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах	Олон улсын “Гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан гэр бүлийн үнэ цэнийг ойлгуулах, аз жаргалтай гэр бүлийн талаар цогц мэдлэг олгох, шинээр батлагдан гарсан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлан таниулах зорилготой “Аз жаргалтай гэр бүл” өдөрлөгийг зохион байгуулж, өдөрлөгт 50 иргэн буюу 25 гэр бүл оролцлоо. “Хайлааст-ОНХХ”-тэй хамтран “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан “АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ” өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгөөр 4 гэр бүлд батламж гардуулж, “Гэр бүл төлөвлөлт”, “Хүүхдийн эрх” сэдвээр мэдээлэл зөвлөгөөг өгч үйл ажиллагаанд 80 өрх хамрагдлаа. “Ахмадад ээлтэй байгууллага”-аар шалгарсан “Гүнтийн тал” ХХК-ны “Өсөх худалдааны төв”-тэй хамтран 3 үеийн уулзалт зохион байгуулж уулзалтад 60 гаруй иргэд хамрагдан, 20 ахмад настанд залуу үеийн төлөөлөл хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулж, урлагийн тоглолт үзүүлсэн.					
7	Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ						
8	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт /өөрийн үнэлгээ/	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
		92,5	4	100	70	100	100
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ /ЗГХЭГ-ын үнэлгээ/	Нэгдсэн үнэлгээ					

Монгол улс дахь хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1	Хөтөлбөрийн нэр : Монгол улс дахь хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь	Хөтөлбөрийн зорилго: Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж, улмаар 0-18 насны хүүхдүүд хүчирхийлэл дарамтаас хамгаалуулах эрхийг бүрдүүлнэ.
2	Санхүүжилтийн эх үүсвэр	JICA
3	Хэрэгжих нийт хугацаа: 2017-2018	Хэрэгжүүлэгч байгууллага: JICA ОУБ /Японы хүүхдийг ивээх сан/
4	Төсөл хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1: Хүүхдийг хүчирхийлэл, дарамт, үл хайхрах, ба мөлжлөгөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, төрийн байгууллагын хүүхэд хамгааллын үйлчилгээ бэхжүүлэн, сонгогдсон зорилтот орон нутаг дахь анхан шатны нэгжийн /хүүхэд хамгааллын хамтарсан багийн/ хүүхэд хамгааллын үйлчилгээний механизмыг дэмжин, олон нийтэд хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг нэмэгдүүлнэ.

5	Зардал	Төсөв /Нийт шаардагдах зардал/	-		
		Үүнд:	Төсөв /2017/	Гүйцэтгэл	Хувь
		Багц 1	4.000.000	3.000.000	
6	Төсөл хөтөлбөрийн зорилт		БИЕЛЭЛТ		
	Зорилт 1: Хүүхдийг хүчирхийлэл, дарамт, үл хайхрах, ба мөлжлөгөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, төрийн байгууллагын хүүхэд хамгааллын үйлчилгээ бэхжүүлэн, сонгогдсон зорилтот орон нутаг дахь анхан шатны нэгжийн /хүүхэд хамгааллын хамтарсан багийн/ хүүхэд хамгааллын үйлчилгээний механизмыг дэмжин, олон нийтэд хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг нэмэгдүүлнэ.		<p>Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Японы хүүхдийг ивээх сангийн дэмжлэгээр 2015-2018 оны хооронд хэрэгжих “Монгол улс дахь хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн Японы хүүхдийн ивээх сан хамтран дүүргийн 9, 10 дугаар хорооны хамтарсан багийн гишүүд, хэсгийн ахлагч нарын бүрэлдэхүүнтэй 50 хүнд чадавхжуулах сургалт зохион байгууллаа. Сургалтаар Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиуд шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан түүнийг хэрэгжүүлэхэд дагалдан гарсан журмуудыг танилцуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, туршлага хуваалцах, кейс менежмент хийх, стресс бухимдлаа даван туулах аргачлал, арга зүйг өгөх зорилгоор зохион байгуулагдаж тус сургалтыг үндэсний хэмжээнд бэлтгэгдсэн сургагч багш нар мэргэжил, арга зүйгээр ханган ажиллаа.</p> <p>Тус төсөл хэрэгжиж буй Баянзүрх дүүргийн 23, 27 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 2, 10 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 9, 10 дугаар хороодын хамтарсан багийн гишүүдийн дунд туршлага солилцох уулзалт хэлэлцүүлгийг 9 дүгээр хорооноос эхлүүлж амжилттай зохион байгууллаа. Уулзалтад Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн 6 хорооны хамтарсан баг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн мэргэжилтнүүд, Японы Хүүхдийг ивээх сангийн төлөөлөгч, чиглүүлэгч нар нийт 30 гаруй хүн оролцсон.</p>		
7	Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ				
8	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт /өөрийн үнэлгээ/	Биелэлт Дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	
		100	1	100	
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ /ЗГХЭГ-ын үнэлгээ/				

Өрхийн тогтвортой тариалан

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
---	---------------------	-----------

1	Хөтөлбөрийн нэр: Өрхийн тогтвортой тариалан /Food security program/	Улаанбаатар хотын захын гэр хорооллын иргэдэд тэр дундаа өрх толгойлсон эмэгтэйчүүдэд газар тариалан эрхлэх гэр бүлийнхээ хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, өрхийн орлогоо нэмэгдүүлж амьжиргаагаа сайжруулах, түүнчлэн хотын иргэдийг эрүүл, чанартай хүнсний ногоогоор хангахад чиглэгдэх юм.		
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Канад улсын хөрөнгө оруулалттай.		
3	Хэрэгжих нийт хугацаа: 2014-2017	Хэрэгжүүлэгч байгууллага: АДРА Монгол ОУБ, Чингэлтэй дүүргийн 14, 18, 19, 17-р хороо		
4	Төсөл хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1: Тогтвортой тариалан эрхлэх замаар өрхийн хэрэгцээг хангах, амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах чадавхжуулах		
5	Зардал	-		
	Төсөв /Нийт шаардагдах зардал/			
	Үүнд:	Төсөв /2017/	Гүйцэтгэл	Хувь
	Багц 1	-	-	
6	Төсөл хөтөлбөрийн зорилт	Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ		
	Зорилт 1: Тогтвортой тариалан эрхлэх замаар өрхийн хэрэгцээг хангах, амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах чадавхжуулах	<p>Канадын Хүнс үр тарианы банк, АДРА-Канадаас санхүүжүүлж буй энэ төслийн хүрээнд 2017 онд хүнсний ногооны үр, 220 өрхөд хоолны гарын авлага зэргийг өгсөн. 2017 оны 4-р сард шим тэжээл судлалын үндэсний төвтэй хамтран Чингэлтэй дүүргийн 14,17,18,19-р хорооны хоол тэжээлийн сургагч багш нарыг хамруулан нэг өдрийн сургалт зохион байгуулсан.</p> <p>2017 оны 4-р сарын 1 нээс 4-р сарын 4 ныг хүртэл үрсэлгээний сургалт хийгдсэн. Бүлэг тус бүрт бөөрөнхий байцаа, лооль, хэмх, бөөрөнхий сонгины үрсэлгээг хийлгэх зорилгоор хороо тус бүрт 2 бүлэгт практик сургалтыг зохион байгуулсан.</p> <p>2017 оны 4-5 сарын хооронд 1 сарын хугацаатай Хан-Уул дүүргийн албан бус насан туршийн боловсролийн төвтэй хамтран оёдлын ахисан шатанд Чингэлтэй дүүргийн төсөлд хамрагдсан 4-н хорооноос тус бүр нэг хүн хамруулсан.</p> <p>2017 оны 5-р сарын 22-26 ны хооронд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын бизнесээ хөгжүүл сургалтад Чингэлтэй дүүргийн төсөлд 18, 19- р хорооноос тус бүр нэг хүн хамруулсан.</p> <p>2017 оны 5-р сарын 2 ний өдрөөс 6-р сарын 10-ныг хүртэл төсөлд хамрагдсан өрхүүдээр айлчилж үүрэг даалгавар, заавар зөвлөмж өгсөн.</p> <p>2017 оны 5-р сараас эхлэн чингэлэг тохижуулах компанитай гэрээ хийгдэж, 18-р хороонд орших худалдааны цэгийг гадарлаж дууссан .</p> <p>2017 оны 6-р сарын 1 нээс 10-р сарын 01 хүртэл <i>cross monitoring</i> буюу дүүрэг хариуцсан мэргэжилтнүүд бусад 3 дүүргүүдийн айл өрх бүрээр явж, заавар зөвлөгөөг өгч байна. дүүргийн 14, 17, 18, 19 дүгээр хорооны төсөлд хамрагддаг 220 өрхийн “Эко хүнсний ногоо” нээлттэй өдөрлөгийг Барилгачдын талбайд зохион байгуулж,</p>		

		<p>иргэдэд амталгаат худалдаа, газар тариалангийн чиглэлээр заавар, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан.</p> <p>Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэсээс санаачлан дүүргийн газар тариалан эрхлэгч нарт АДРА ОУБ-тай хамтран “Өвлийн хүлэмж” сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалтанд 52 иргэн оролцож, мэдлэг мэдээлэл авсан.</p> <p>Сургалтын үеэр Тариаланчдад “Тариаланчдын үнэмлэх”, “Гарал үүслийн гэрчилгээ олгох” журмын талаар мэдээлэл өгсөн.</p>		
7	Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ			
8	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт /өөрийн үнэлгээ/	Биелэлт Дундаж	Зорилтын тоо	Зорилт1
		100	1	100
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ /ЗГХЭГ-ын үнэлгээ/			